




**СУРГУУЛИЙН ҮДИЙН ЦАЙНЫ ЗААЛНЫ ТОХИЖИЛТ
ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар БХБАЦ/ОНХС/03

2025 оны 03 дугаар сарын 25

Баянсайр

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Нэг талаас Баянхонгор аймгийн Баацагаан сумын Засаг дарга С.Энхтөр (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас Монгол улс "Дэрстэй таван салаа" ХХК 5380596 тоот регистрийн дугаартай (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож уг гэрээг байгуулав.
- 1.2. Монгол Улсын Иргэний хууль, Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.3. Захиалагч нь Баянхонгор аймгийн Баацагаан сумын ЕБСургуулийн үдийн цайны заалны тохижилт хийх ажлыг (цаашид "ажил" гэх) 15,000,000 /Арван таван сая төгрөг/-өөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хоёр. Гэрээний үнэ, төлбөр төлөх нөхцөл

- 2.1. Захиалагч нь ажлын нийт үнэ болох 15,000,000 /Арван таван сая төгрөг/-ийг Баацагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлнэ.
- 2.2. Санхүүжилтыг гүйцэтгэл, тоо хэмжээ, сорьц, сертификат ил далд ажлын актыг баталгаажуулсан фото зураг, гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн баримтууд болон нэхэмжлэх, төлбөрийн баримт зэргийг үндэслэн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоно.
- 2.3. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - а. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл
 - б. Техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ
 - в. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь
- 3.2. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болох ба хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ.
 - 3.2.1. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

Дөрөв. Талуудын эрх үүрэг

4.1. Захиалагчийн эрх үүрэг:

- 4.1.1. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхэд шаардлагатай бүхий л нөхцөл, бололцоог хангаж ажиллана.
- 4.1.2. Захиалагч тал нь гэрээт ажлын чанар, хугацаа, гүйцэтгэлд хяналт тавин, гэрээт ажлыг эхлүүлэх, үргэлжүүлэх, зогсоох эрхтэй.
- 4.1.3. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийсэн ажилд үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.
- 4.1.4. Захиалагч гүйцэтгэгчээс ажлыг чанарын өндөр түвшинд, заасан хугацаанд хийж дуусгахыг шаардах эрхтэй бөгөөд дууссан ажлыг хүлээж авахад чанарын доголдол, дутагдал илэрсэн тохиолдолд түүнийг засуулах тухай бүрт нь доголдлыг арилгаагүй бол ажлын хөлсөнөөс хасаж акт, торгууль тавих эрхтэй.

4.2. Гүйцэтгэгчийн эрх үүрэг:

- 4.2.1. Гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтын дагуу бүх нөхцөл, болзолд нийцүүлэн ажлыг гүйцэтгэж, зөрчил гарсан тохиолдолд арилгах үүрэгтэй.
- 4.2.2. Сургуулийн үдийн цайны заалны тохижилт хийх ажлыг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн гүйцэтгэж чанартай хийж гүйцэтгэнэ.
- 4.2.3. Ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
- 4.2.4. Гүйцэтгэгч тал ажлыг зориулалтын техник хэрэгслээр чанартай ухаж гүйцэтгэнэ.
- 4.2.5. Гүйцэтгэгч тал өөрсдийн хүчээр мод суулгацыг тарих ажлыг гардан зохион байгуулна.
- 4.2.6. Гүйцэтгэгч тал намар мод, суулгацын ургалтыг үнэлэн нөхөн тарилтыг хийж гүйцэтгэнэ.

4.3. Сум, орон нутгийн эрх, үүрэг

- 4.3.1. Сум, орон нутаг нь ажил гүйцэтгүүлэхэд шаардлагатай бүхий л нөхцөл, бололцоог хангуулж ажиллана.
- 4.3.2. Сум, орон нутаг нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийсэн ажилд байнгын хяналт тавьж, хяналтын хуудас бөглөж ажиллана.
- 4.3.3. Сум, орон нутаг нь гүйцэтгэгчээс ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээнд заасан хугацаанд хийж дуусгахыг шаардах эрхтэй.
- 4.3.4. Сум, орон нутаг нь ажил хугацаандаа хийгдэхгүй удаашралтай байх, ажил техникийн тодорхойлолтын дагуу хийгдэхгүй байгаа нөхцөлд холбогдох байгууллагад даруй мэдэгдэж хүсэлт гаргах, албан шаардлага хүргүүлэх үүрэгтэй.
- 4.3.5. Сум, орон нутаг нь захиалагч болон ашиглагч байгууллагын үүднээс ажил хүлээлцэх комисст орж ажлыг хүлээж авах, холбогдох газруудад тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Тав. Зөрчил ба доголдол

- 5.1. Ажил гүйцэтгэх хугацаанд гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 5.2. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.

- 5.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 5.4. Гүйцэтгэгч доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 5.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

Зургаа. Гэрээг цуцлах

- 6.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 6.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 20 хоног ажлын талбайг орхисон;
- 6.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
- 6.1.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
- 6.1.4. Ажил гүйцэтгэх хугацаанд гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 6.1.5. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

Долоо. Бусад заалт


- 7.1. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
- 7.2. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
- 7.3. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 7.4. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: [2025.03.25-2025.04.25]
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: [2025.04.10]
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: [2025.04.15]
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: ["Хийхгүй"]
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: [80 хувь]
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: [Ажлын гүйцэтгэлээр олгох]
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа:
ГЕН 6.8.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: [Үгүй]

ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.5 хүртэл хувь]
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтооно]

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

